



**НИЙСЛЭЛИЙН  
НИЙТИЙН ТЭЭВРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/21

Улаанбаатар хот

**Нийтийн тээврийн үйлчилгээний  
чиглэлийн замналд зогсоол нэмэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/536 дугаар захирамжаар баталсан “Нийтийн тээврийн бодлогын газрын дүрэм”-ийн 4.1.2.1, 4.1.2.2, 7.1.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, автобусны зогсоол хоорондын зайг ойртуулж иргэдийн эрэлт хэрэгцээг хангах үүднээс Х:8 “Найрамдал зуслан – 5 шар” чиглэлийн замналд өөрчлөлт оруулж Их Монгол өргөө (баруун, зүүн), Найрамдлын пост (баруун, зүүн) зогсоолыг шинээр нэмж хавсралтаар баталсугай.

2. Дээрх чиглэлийн өөрчлөлтийг программ хангамжид оруулж үйлчилгээг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс эхлүүлэхийг Тээврийн бодлого, судалгааны хэлтэс (Ш.Оюумаа)-т, тухайн чиглэлийн ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Зорчигч тээврийн хэлтэс (Х.Баасансүрэн)-т, ажлын гүйцэтгэлийг үндэслэн холбогдох санхүүжилтийг тооцож ажиллахыг Санхүү, аж ахуйн хэлтэс (Б.Бадамдорж)-т, шинээр нэмэгдсэн зогсоолуудад автобус зогсох хэвшлийг бий болгохыг Хяналт шалгалтын хэлтэс (Ц.Мягмар)-т, иргэдэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, удирдлагын хэлтэс (З.Цэвээндорж)-т тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан тус газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 09-ны өдрийн А/105 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын хэлтэс (З.Цэвээндорж)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Г.БИЛГҮҮН

D:\alban khereg\явсан бичиг-2026\TUSHAAI.docx

TY6995 9024050915 2117428

1726020241



